

АРВАЙХЭЭР СУМБЫН ЗАСАГ ДАРТЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН
М.ЭРДЭНЭЧИМЭГИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь	
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Зорилт 1. "ИРГЭДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ, ӨВЧЛӨЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД				
						3	4			5
1		2								
Зорилт 1. "ИРГЭДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ, ӨВЧЛӨЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД										
1.	Арга хэмжээ 1.1. Иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулах, эрт илрүүлэг, эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд хамрагдалтын явц мэдээллийг нэгтгэж ажиллах.	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан хувь	81	81	Оны эхний 10 сарын байдлаар артерийн гипертензийн эрт илрүүлэг үзлэгт 18-аас дээш насны 14826 иргэн хамрагдахаас 12154 буюу 81.9 хувь нь хамрагдаж, 70 тохиолдол, чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт 11457 иргэн хамрагдахаас 10224 буюу 89,2 хувь нь хамрагдаж, 30 тохиолдол, элэгний хорт хавдрын эрт илрүүлэгт 2259 иргэн хамрагдсанаас 4 тохиолдол тус тус онош батлагдсан байна. Хөхний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгт 7633 хүн хамрагдахаас 6697 хүн буюу 87,7 хувь, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгт 1967 иргэн хамрагдахаас 1631 буюу 82,9 хувь, нь хамрагдаж, халдварт бус өвчлөлөөс урьдчилсан сэргийлэх эрт илрүүлгийн үзлэгийн дундаж хамрагдалт 85,4 хувьтай байна. Эрт илрүүлгийн үзлэг шинжилгээгээр шинээр 36 хорт хавдар бүртгэгдсэн нь өмнөх оноос 16 буюу 4,5 пунктээр буурсан үзүүлэлттэй байна. Хавдрын өвчлөлд хоол боловсруулах зам элэг, ходоод, нойр булчирхай, уушгины хавдар зонхилж байна. Эрт илрүүлэгт 05 сарын байдлаар 2094 иргэн хамрагдсанаас эмэгтэй 1262 эрэгтэй 832 хүн хамрагдсан байна. Илрүүлэгт хамрагдалт өссөн дүнгээр 86,6 хувьтай байна. Урьдчилан сэргийлэх үзлэгт ерөнхий боловсролын 6 сургуулийн 6488				2025.01.02 2025.11.31	100

					хүүхэд хамрагдсанаас 1543 нь өвчлөлтэй гарч 1143 хүүхдийг эмчлэн эрүүлжүүлж, 324 хүүхэд эмчлүүлж байна. 15 цэцэрлэгийн 3899 хүүхэд хамрагдсанаас 363 хүүхэд өвчлөлтэй гарснаас 193 хүүхдийг эмчлэн эрүүлжүүлээд байна. Эрүүл мэндийн сайдын санаачилгаар зохион байгуулагдсан "24/3 Шүдээ зөв угаа" үндэсний аяны хүрээнд аймгийн эрүүл мэндийн газартай хамтран 1 сарын аяныг зохион байгуулж Арвайхээр сумын ерөнхий боловсролын 6 сургуулийн 1 дүгээр ангийн 1064 хүүхэд хамрагдахаас 934 хүүхдийг буюу 87,8 хувийг хамруулж, шүд цоорлоос хамгаалах түрхлэг, шүд авах, ломбо тавих, сүвгийн эмчилгээг шаардлагатай хүүхдүүдэд хийсэн.		
2	Арга хэмжээ 1.2 Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалт, мэдээллийг эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран үр нөлөөтэй зохион байгуулах	Танхимаар зохион байгуулсан сургалтын тоогоор	10	12	Эрүүл мэндийг дэмжих сарын аяны хүрээнд Өрхийн эрүүл мэндийн төвүүд, 1 сургууль, 8 цэцэрлэг зохион байгуулсан ажлын тайлан ирүүлсэн. Түүнээс танхимаар хүний папиллома вирус түүнээс урьдчилан сэргийлье", "Менингококкт өвчин, түүнээс урьдчилан сэргийлэх, Халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлье", "Давсны хэрэглээгээ бууруулцгаан", "Умайн хүзүүний хорт хавдраас урьдчилан сэргийлье, Эрчүүдийн эрүүл мэнд, хорт зуршил, гэр бүл төлөвлөлт, өсвөр үеийн эрүүл мэнд гэх мэт 30 гаруй сэдвээр 40 удаагийн сургалт зохион байгуулж 2430 иргэн давхардсан тоогоор хамрагдсанаас хүүхэд 1335, иргэн 786, албан хаагч 309, тус сургалтад хамрагдаж мэдээлэл авсан байна. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн тогооч нарт "Хүнсний аюулгүй байдал эрүүл ахуй", Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, болон асран хамгаалалт нар "Зүрх сэтгэлийн боловсрол олгох", 13 багийн зорилтот бүлгийн эрчүүдэд "Эрчүүдийн эрүүл мэнд" сургалтыг тус тус зохион байгуулж иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгосон.	2025.01.02 2025.11.31	100

		2. цахимаар сургалт мэдээлэл авсан иргэдийн хандалтын тоо	15	18	Уян сэтгэл өрхийн эрүүл мэндийн төвийн пэйж хуудсаараа архи, тамхинд донтох эмгэгээс сэргийлэх зэрэг 2 төрлийн видеог давтамжтай байршуулж 1161638,4 төрлийн постер-22,638, архи, тамхи, дэлгэцийн донтолтоос сэргийлэх 3 төрлийн цуврал контентыг давтамжтай байршуулж 1843649 хүний хандалт авсан байна. Түшиг дөнгөөн өрхийн эрүүл мэндийн төв пэйж хуудсаар халдварт болон халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, мэдлэг хандлагыг нэмэгдүүлэх нийт 600 удаагийн мэдээ, мэдээлэл, 21 төрлийн постер, 12 видео шторк бэлтгэн байршуулж, 67582, Нарны дөш эмнэлэг Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл дадал хэвшил, эрүүл мэндийн боловсрол олгох 60 видео бичлэг, Улаан бурухан, ХЛВ-ийн халдвар өвчний тухай, өсвөр үеийнхэнд тулгардаг асуудлыг хэрхэн шийдэх вэ?, өсвөр үеийнхэнд зориулсан зөвлөмж, өсвөр насны жирэмслэлтийн сул тал, хүүхдүүдээ дэлгэцийн донтолтоос сэргийлвэ, шүдээ зөв угаах суцгаах, аюулгүй хоол хүнсний 5 түлхүүр, хүүхдийг зодож шийтгэхгүй байх, гэх мэт 20 гаруй сэдвийн хүрээнд 60 төрлийн мэдээлэл, зөвлөгөөг нийтэлж, давхардсан тоогоор 34165 хүний хандалт авсан байна.	2025.01.02 2025.11.31	100
3	Арга хэмжээ 1.3. Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, хорт зуршил, мансууралтай тэмцэх талаар сургалт нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах;	Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор	5	6	Иргэдийн сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, сэтгэл гутрал, уур бухимдлаас урьдчилан сэргийлэх зөвлөгөө, Амиа хорлохоос урьдчилан сэргийлэх, стрессийг даван туулах аргууд, стресс тайлах цэгэн бариа, амьсгалын дасгалууд гэх мэт 203 гаруй төрлийн мэдээлэл, 3 төрлийн видео зөвлөмж, 44 төрлийн постерыг байгууллагын болон орон нутаг идэвхтэй ажилладаг фэйсбүүк группт нийтэлснээр давхардсан тоогоор 1357417 хүн хандаж мэдээллээр хантагдсан байна. Өсвөр үе, ахлах ангийн сурагчдад зориулсан нийт 14 удаагийн танхимын сургалтыг архи тамхины хор уршиг, электрон тамхины хор уршиг, сэтгэл зүй сэдвүүдээр зохион байгуулж, нийт 600 гаруй хүүхдийг хамруулсан байна. Хорт зуршлаас	2025.01.02 2025.11.31	100

					урьдчилан сэргийлэх танхимын сургалтад 1000 гаруй иргэн, хүүхэд хамрагдсан байна.		
					Арвайхээр сумын Засаг даргын дэргэдэх зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 07-ны хурдаар 2024 оны 1,2 дугаар ээлжийн цэрэг татлагаар өвлөлтэй гарсан залуучуудын эрүүлжүүлэлтийн явц, үр дүнгийн тухай мэдээллийг хэлэлцүүлэхэд 2024 оны 1,2 дугаар ээлжийн цэрэг татлагаар өвчлөлтэй гарсан гарсан 356 залуучуудаас 116 буюу 32,5 хувийг эрүүлжүүлсэн байна. 2025 оны 1, 2 дугаар ээлжийн цэрэг татлагад 1-13 дугаар багийн 857 залуу эрүүл мэндийн үзлэгт хамрагдсанаас 439 буюу 51,2 хувь нь өвчлөлтэй гарч эрүүл мэндээр тэнцээгүй байна. Өвчлөлийн 32,3 хувь нь гэмтэл мэс заслын, 14,8 хувь нь дотор, 11,8 хувь нь чих, хамар хоолойн, 9,5 хувь мэдэрэл, 9,3 хувь нь зүрх судасны, 9,1 хувь нь нүдний, 6,6 хувь нь арьс харшлын, 2,2 хувь нь сүрьеэгийн, 1,3 хувь нь шүдний, 1,1 хувь нь халдварт өвчин 0,6 хувь нь сэтгэцийн, 0,9 хувь нь бусад өвчний оноштой байна. Эмчлэгдэх боломжтой оноштой залуучуудад өрхийн эрүүл мэндийн төвүүд эмчлэн эрүүлжүүлэх ажлыг хийж байна. Бэлгийн замын халдварт өвчний 7 тохиолдлыг бүрэн эмчлэн эрүүлжүүлсэн. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн "Дэмжих төв"-тэй хамтран ажиллаж 1 дүгээр ээлжийн цэрэг татлагаар биеэр ирж комиссоор орсон залуучуудаас эрт илрүүлэгт хамрагдах боломжтой 165 залуучуудыг буюу 33,8 хувийг хамруулан ажилласан. Цэргийн насны залуучуудын эмчлэн эрүүлжүүлэлтийн тайлан, мэдээг rpt хэлбэрээр бэлтгэн танилцуулсан.		
4	Арга хэмжээ 1.4. Цэргийн насны залуучуудын эрүүлжүүлэлтийн ажлыг өрхийн эрүүл мэндийн төв, багийн ажлын албатай хамтран зохион байгуулж үр дүнг тооцох	Эрүүлжүүлэх арга хэмжээ зохион байгуулсан тоо	1	2	2025.01.02 2025.11.31	0	
	Цэргийн албанд тэнцсэн залуусыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулсан хувиар		100	100	2025 оны 1,2 дугаар ээлжийн цэрэг татлагад эрүүл мэнд бие бялдараа тэнцсэн 57 залууг Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 8 төрлийн шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулан Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн холбогдох мэргэжилтэн, эмч	100	

					нартай хамтран ажиллаж нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, шинжилгээний цагийг авч, үзлэг шинжилгээнд хугацаанд бүрэн хамруулж хуваарьт цэргийн ангиудад нь хүлээлгэн өгсөн. 2024 онд 47 залуу, 2025 онд 59 залуу цэргийн жинхэнэ албанд тэнцсэн нь өмнөх жилээс 8 залуу буюу 14 хувиар өссөн үзүүлэлтэй байна.		
	Бүсийн оношилгоо эмчилгээний төвд эрчүүдийн кабинет тохижуулах	-	1		Андорлотиин тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Бүсийн оношилгоо эмчилгээний төвд кабинет тохижуулах, тоног төхөөрөмж авахад сумын Засаг даргын Тамгын газраас 15,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж үзлэгийн болон эхоны ор, тарианы тавиур, даралтын аппарат, үзлэгийн хаалт, биеийн өндөр жин хэмжигч, хүлээлгийн сандал, тусламж үйлчилгээний багц, ариутгалын квас, яаралтай тусламжийн тэргэнцэр, кушетка, лоташка зэрэг тоног төхөөрөмжийг суурилуулсан. 2025 оны 10 дугаар сарын байдлаар эрчүүдийн кабинетаар 1034 иргэн үйлчлүүлж, эмчлэн эрүүлжүүлсэн. Нийт үйлчлүүлсэн иргэдээс 385 нь Арвайхээр сумын харьяатай иргэн байна	2025.01.02 2025.11.31	100
5	Арга хэмжээ 1.5. Эрчүүдийн эрүүл дэмжих арга хэрэгжүүлнэ	Эрүүл мэндийн явуулын үйлчилгээ зохион байгуулсан тоогоор	-	1	Эрүүл мэндийг дэмжих аяны хүрээнд: Өрхийн эрүүл мэндийн төвүүд аймгийн Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Зэвсэгт хүчний 256-р анги, Арвайхээр тохижилт үйлчилгээ Арвайхээр цэцэрлэгжилт, Арвайхээр Нийтийн тээвэр, гэрэлтүүлэг, ОНӨААТҮГазар, ерөнхий боловсролын 4, 5 дугаар сургууль, мэргэд лаборатори сургууль, 7 дугаар цэцэрлэгийн эрэгтэй албан хаагчид болон иргэд нийт 640 эрэгтэйчүүдэд эрүүл хооллолт, архи тамхины хор уршиг, бэлгийн замаар дамжих халдвар түүнээс урьдчилан сэргийлэх нь сэдэвт сургалтаар эрүүл мэндийн боловсрол олгож, биеийн ерөнхий үзлэг, эхо, оношилгоо, шинжилгээ, элэг, будуун гэдэсний хавдар илрүүлэх түргэвчилсэн тест, сахар, холестерин шинжилгээ хийж урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан зөвлөгөө мэдээлэл өгч	2025.01.02 2025.11.31	100

				ажилласан. Эрүүл мэндийг дэмжих аяны хүрээнд хүрээнд 2,3,4,5,10,12,14 дүгээр цэцэрлэг зэрэг 7 цэцэрлэг Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль эрэгтэй ажилчидаа эрүүл мэндийн сургалтад болон эрүүл мэндийн үзлэг оношилгоонд хамруулан эмчлэн эрүүлжүүлсэн. Эрчүүдийн эрүүл мэндийг дэмжих зорилгоор өрхийн эрүүл мэндийн төвүүд болон холбогдох байгууллагуудтай хамтран 11 удаагийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд 700 гаруй эрчүүдийг хамруулж эрүүл мэндийн өөрчлөлтэй гарсан иргэдийг дараагийн шатны эмнэлэг, эмчид илгээж, заавар зөвлөгөө өгч ажилласан байна. Арвайхээр сумын 13 багийн 30 гаруй байнгын асаргаатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд ахмад настангаар 2025 оны 06 дугаар сарын 25-наас 07 дугаар сарын 04-ний хооронд багийн Засаг дарга, Нийгмийн ажилтан, Өрхийн эмч, Нийгмийн бодлогын мэргэжилтэн нар тэрээр орж анхан шатны үзлэг хийж зөвлөгөө мэдээлэл өгч, тэдэнд тулгамдаж буй асуудал, санал бодлыг сонсож сум орон нутгаас хийгдэж буй ажлын цаг үеийн мэдээлэл өгч Арвайхээр сумын Виратаул аяллыг хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон тэдний асран хамгаалагч нарт үзүүлэн сум орон нутгийн түүх соёлтой танилцан сумын түүхэн дурсгалт газраар аялуулсан. Хөдөөгийн залуучуудын хөгжил оролцоог нэмэгдүүлэх хууль эрх зүйн мэдээлэл хүргэх тэдний санал бодлыг сонсох, эрүүл мэндийн анхан шатны үзлэг оношилгоонд хамруулах зорилгоор Залуу малчдын зөвлөгөөнд оролцсон 65 малчныг 7 төрлийн үзлэг шинжилгээнд хамруулж зөвлөгөө мэдээлэл өгсөн. “Залуусын боломж” явуулын үйлчилгээгээр 45 малчин өрхөөр орж биеийн ерөнхий үзлэг, элэгний В, С вирус, сахар илрүүлэх шинжилгээнд хамруулсан. Хүүхдүүдийг анхан шатны үзлэгт хамруулж, эмийн багц олгосон.		
--	--	--	--	---	--	--

6	Арга хэмжээ 1.6. БЗХӨ /ДОХ тэмбүү/ өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлнэ	Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор	3	4	Өрхийн эрүүл мэндийн төвүүд эрүүл мэндийг дэмжих сарын аяны хүрээнд "нөхөн үржихүй, бэлгийн замын халдварт өвчин, түүнээс урьдчилан сэргийлэх тухай", "бэлгийн замаар дамжих халдвар" сэдвүүдээр 9 удаагийн танхимын сургалт зохион байгуулж, ерөнхий боловсролын сургуулиудын 10-12 дугаар ангийн сурагчид, Цагдаагийн газрын алба хаагчид, Онцгой байдлын газрын алба хаагчид, Зэвсэгт хүчний 256-р ангийн алба хаагчид, ерөнхий боловсролын 1, 4, 5 дугаар сургуулийн ажилтан, албан хаагчид, 2025 оны 1, 2 дугаар ээлжийн цэцэг таглагад хамрагдсан залуучууд, нийт 1360 иргэн хамруулсан. Бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлж эмчлэн эрүүлэхийн ач холбогдлын тухай агуулга бүхий 6 төрлийн гарын авлагыг 2966 иргэнд хүргэсэн. Өрхийн эрүүл мэндийн төвүүд цэргийн насны залуучууд, уул уурхайн ажилчид, жирэмсэн, өрх толгойлсон эмэгтэйчүүд зэрэг зорилтот бүлгийн 2033 иргэнийг хүний дархлал хомсдолын вирус, тэмбүүгийн халдвар илрүүлэх түргэвчилсэн оношлуураар шинжилгээнд хамруулсан. Энэ оны 10 дугаар сарын байдлаар тэмбүүгийн 62 тохиолдол батлагдсан нь өмнөх жилийн мөн үеэс 18 тохиолдлоор буюу 29,1 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Тэмбүүгийн халдвар 10,000 хүн амд 16,5 ногдож байна. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, аймгийн эрүүл мэндийн газраас бэлтгэн гаргасан пост, постер, видео бичлэг зэргийг өрхийн эрүүл мэндийн төвүүд байгууллагын цахим хуудсаараа дамжуулж, 7851 хүний хандалт авсан.	2025.01.02 2025.11.31	100
---	---	---	---	---	---	--------------------------	-----

7	Арга хэмжээ 1.7 Байгууллагын албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах;	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан албан хаагчдын хувь	75	90	Байгууллагын үндсэн ажилтан, албан хаагчдыг Улаанбаатар хот дахь Бриллиант эмнэлэгт эрүүл мэндийн багц шинжилгээ оношилгоонд хамруулахад үндсэн 77 албан хаагчаас 63 нь буюу 81,9 хувь нь хамрагдсан бол 14 буюу 18,1 хувь нь өөрсдийн хүсэлтээр хамрагдаагүй. Үзлэг оношилгоонд хамрагдсан нийт албан хаагчдаас дийлэнх олонход нь дараах өөрчлөлтүүд түгээмэл байна. Үүнд: 54 хүн буюу 88, хувь витамин Д дутагдалтай, элэг, цөс нойр булчирхайн эмгэг 43 хүн буюу 71 хувь, бодисын солилцооны эмгэг 18 хүн буюу 30 хувийг эзэлж байна. Үзлэгийн үеэр албан хаагч тус бүрд, гэрээ дүгнэсэн акт тайланд мөн зөвлөмжийг бичиж ирүүлснийг байгууллыг дундын группэд тавьж албан хаагчдад хүргэсэн. Байгууллагын эрт илрүүлэгт хамрагдах боломжтой 45 албан хаагчаас 43 албан хаагчийг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн дэмжих төвд эрт илрүүлэгт хамруулсан нь хамрагдах боломжтой албан хаагчдын 95,5 хувийг эрт илрүүлэгт хамруулсан байна.	2024.01.02 2024.12.01	100
8	Арга хэмжээ 1.8. Архины хамааралтай, гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг иргэдийг төрийн болон сайн дурын болон албадан эмчилгээнд хамруулах	эмчилгээнд хамрагдсан иргэдийн тоогоор	17	10	Сумын хэмжээнд архины хамааралтай 190 иргэн байгаагаас эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд 14 иргэнийг, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн сэтгэц наркологийн тасагт 3 иргэнийг хэвтүүлэн эмчлүүлж, 2 иргэнийг 3 сараар Төв аймаг болон Улаанбаатар хотод албан эмчилгээнд тус тус хамруулсан байна. 3 иргэнийг албан эмчилгээнд хамруулахаар материал бүрдүүлсэн, 6 иргэний материалыг бүрдүүлэн ажиллаж байна. 7 иргэнийг түр ажлын байранд хамруулж архины хамааралтай 2 өрхөд түлээ түлш, хүнсний нийт 500,000 төгрөгний тусламж үзүүлсэн байна. 1 иргэн Өөрөө өөртөө туслах бүлэгт элсэн явж байна. Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газраас зарласан Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний тендэрт Оточжаргалан ХХКомпани	2025.01.02 2025.11.31	100

					буюу Ариунсанаа эмнэлэг шалгарч Арвайхээр сумын 13 багийн согтуурах, мансуурах, донтох, өвчтэй 83 иргэнд анхан шатны үнэлгээ хийж зан үйлд нөлөөлөх нөлөөллийн сургалт сурталчилгаанд хамруулан, сэргээн засах үйлчилгээ үзүүлж, шаардлагатай өөрөө өөртөө туслах бүлэг, сэтгэл зүйн үйлчилгээ, гэх мэт бусад үйлчилгээнд болон холбогдох байгууллагуудтай холбон зуучлах зэргээр хамтран ажиллаж байна. Давхардсан тоогоор 150 орчим иргэнд буюу 78,9 хувьд сургалт нөлөөллийн арга хэмжээнд хамруулах, эрүүл мэндийн үзлэг шинжилгээ, түр ажилд хамруулах зэргээр хүрч үйлчилсэн байна. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамруулах эмнэлэгт хэвтүүлэх нөхөн сэргээх үйлчилгээ, албадан эмчилгээнд хамруулах гэхээр эрүүл мэндийн даатгалаа хэдэн жилээр төлөөгүй байдаг асуудал нь эрүүлжүүлэх эмчилгээнд хамруулах боломжгүй байдал үүсгэдэг. Мөн сургалт нөлөөллийн арга хэмжээнд давтамжтай хамруулахад архи уугаад хэд хоногоор олдохгүй байх эсвэл согтуу байх зэрэг асуудал тулгарч байна.		
Зорилт 2. "НИЙТИЙН БИЕИЙН ТАМИРЫГ ХӨГЖҮҮЛЭХ, ИРГЭДИЙГ ЭРҮҮЛ АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГТ ТӨЛӨВШҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1	Арга хэмжээ 2.1. Монгол Улсын Засгийн газраас зарласан "Монголд зочлох жил" өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, Биеийн тамир спортын салбарын түүхт 100 жилийн ойн хүрээнд иргэдийг идэвхтэй амьдралын хэв маягт уриалсан олон талт арга хэмжээг холбогдох	Зохихон байгуулсан арга хэмжээний тоогоор	9	10	"Эрүүл чийрэг-Өвөрхангайчууд" уриан дор өглөөний дасгал, гүйлт, алхалт, фитнес, спиннинг, хийн дасгал, нийтийн болон шугаман бүжиг, Дартс, Ширээний теннис, газрын болон агаарын иог, усан бассейн зэрэг төрөлд давхардсан тоогоор 1685 иргэн идэвхтэй хичээллэж байна. Мөн "Зөв цаг клуб"тэй хамтран Нийтийн бүжгийн 7 хоногийн аян, Шугаман бүжгийн 7 хоногийн аян, Мөрөөдөл 160 Спиннинг, жамп клубтэй хамтарсан 7 хоногийн аяныг тус бүр зохион байгуулсан. Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй "Эрүүл Монгол хүн" үндэсний хөдөлгөөний хүрээнд дараах	2025.01.02 2025.11.31	100

байгууллагуудтай зохион байгуулах	хамтран		тэмцээн уралдааныг спортын мэргэжлийн клуб, холбоотой хамтран зохион байгууллаа. Үнд: "Төвийн бүсийн спортын их наадам"-ыг Төвийн бүсийн спортын их наадамд (волейбол, сагс, шатай, үндэсний бөх) 4 төрлийн багийн тэмцээнд 81 багийн 564 тамирчин, ганцаарчилсан (ширээний теннис, шатар, даам, үндэсний сур) 4 төрлийн тэмцээнд 71 нийт 8 төрлийн спортын тэмцээнд 635, (эрэгтэй-365 эмэгтэй-270) тамирчин хурд хүч, оюун ухаан, авхаалж самбайгаа дайчлан, цэц мэргэнээ сорин оролцож дараагийн шатны тэмцээнд оролцох аваргуудаа шалгаруулсан. Монголын шатайн нумт харвааны холбооны аймгийн салбар зөвлөл хамтран ахмадын "Нумт харваа 2025" нээлтийн тэмцээнийг амжилттай зохион явуулсан. Тэмцээнд 10 сумын 16 багийн 122 харваачид оролцсон. Арвайхээр Лиг 4 сарын турш үргэлжилж Лигийн шигдгүүдээ тодруулсан. Тус тэмцээнд 18 багийн 140 гаруй тамирчид хурд хүч, авхаалж самбайгаа дайчлан оролцсон. Авзагын хүчтэн үндэсний бөхийн холбоотой хамтран Дархан аварга Д.Цэрэнтогтохын нэрэмжит хүүхдийн Улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж 15 аймаг 5 дүүргийн 350 хүүхэд багачууд оролцсон. Мөн "Ирээдүйн аварга" цуврал барилдааныг 2 удаа зохион байгуулж 370 хүүхэд, нийт 720 тамирчин оролцсон байна. Өвөрхангай марафон. Тэмцээнд 276 хүүхэд 147 насанд хүрэгч хурэгч нийт 423 хүн гүйлт болон унадаг дуугийн төрлүүдэд оролцлоо. Далантуруу дартсын клубтэй хамтран сумын "Дартс"-ын аварга шалгаруулах тэмцээнийг 6 төрлөөр зохион байгуулж, 190 тамирчин оролцож аваргуудаа шалгаруулсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд спортын 5 төрөлт тэмцээнийг зохион байгуулсан. Засаг даргын Тамгын газраас мэргэжлийн спорт клубүүдтэй хамтран сумын аварга шалгаруулах тэмцээн уралдаан болон Ерөнхий боловсролын 6 сургууль, сургуулийн өмнө байгууллага буюу 15 цэцэрлэг, 13 багаас, багийн иргэд, ажилтан албан	
--------------------------------------	---------	--	---	--

					хаагчдын дунд 116 удаагийн тэмцээн уралдааныг зохион байгуулж давхардсан тоогоор 21360 хүн оролцсон байна.		
2	Арга хэмжээ 2.2. Арвайхээр суманд үйл ажиллагаа явуулж байгаа спорт заалнууд 7 хоногийн 1 өдөр үнэ төлбөргүй үйлчлэх боломжийг судлан, хэрэгжүүлэх	Заалны тоогоор	6	6	Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/21 захирамжаар хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөв, дадал бий болгох зорилгоор ерөнхий боловсролын сургуулиудын спорт заалыг өглөө 06:00-08:00 цагийн хооронд иргэдэд үнэ төлбөргүй үйлчилдэг болгохоор захирамжилсан энэ хүрээнд ерөнхий боловсролын 6 сургуулийн 6 спорт заал өглөөний цагаар иргэдэд үнэгүй үйлчилж байна. Спорт заалаар 9000 гаруй иргэд үйлчлүүлснээс 80 хувь нь сурагчид байна.	2025.01.02 2025.11.31	100
3	Арга хэмжээ 2.3 Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилыг авч үр дүнг тооцох	Бие бялдрын сорилд хамрагдсан иргэдийн хувь	10	10	Бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг 2025 оны 04 дүгээр сарын 29-өөс 10 дугаар сарын 25-ны өдрийн хооронд зохион байгуулж, сорилд хамрагдвал зохих 2-64 насны нийт 32115 иргэнээс 4675 иргэн буюу 14.5 хувийг хамруулж сорилын мэдээллийг программд шивж оруулсан. Үүнд: Ерөнхий боловсролын 6-18 насны 1264 сурагч, цэцэрлэгийн 2-5 насны 2002 хүүхэд, 15-64 насны 1409 иргэнээс авсан. Сорилд хамрагдсан насанд хүрэгчдийг биеийн жингийн индексээр авч үзвэл:хэвийн жинтэй 853 буюу 60,5 хувь, туранхай 77 буюу 5,4 хувь, илүүдэл жинтэй 479 буюу 33,9 хувийг тус тус эзэлж байна.	2025.01.02 2025.11.31	100
4	Арга хэмжээ 2.4 Спортын төрлүүдээр сумын аварга шалгаруулах тэмцээнийг байгуулах;	Спортын арга хэмжээ зохион байгуулагдсан байна	4	6	Монголын шагайн нумт харвааны холбооны аймгийн салбар зөвлөл, Далан туруу даргсын холбоо, Сагсан бөмбөгийн холбоо, Авсагын хүчтэн бөхийн холбоо, аймгийн Нийтийн бүжгийн холбоо, Шатрын холбоо, Чөлөөт бөхийн холбоо, Соёмбот УАЗ клуб, Арвайн дайчид, Таеквондогийн "Шонхор" клуб, Гэгээн хантай клуб зэрэг мэргэжлийн холбоод клубүүдтэй хамтран клубийн мэргэжлийн чиглэлээр зохион байгуулсан тэмцээн уралдаанд дэмжлэг үзүүлж 11 мэргэжлийн холбоо, клубүүдтэй хамтран ажиллаж орон нутгийн төсвөөс 91,7 сая төгрөг зарцуулсан. Засаг даргын Тамгын газраас мэргэжлийн спорт клубүүдтэй хамтран сумын	2025.01.02 2025.11.31	100

				аварга шалгаруулах тэмцээн уралдаан болон ерөнхий боловсролын 6 сургууль, сургуулийн өмнө байгууллага буюу 15 цэцэрлэг, 13 багаас, багийн иргэд, ажилтан албан хаагчдын дунд 116 удаагийн тэмцээн уралдааныг зохион байгуулж давхардсан тоогоор 21360 иргэн оролцсон байна. Бүгд найрамдах Итали улсын Турин хотод зохион байгуулагдсан Тусгай олимпод оролцсон 2 тамирчинд 4,0 сая төгрөг, Вьетнам улсад зохион байгуулагдах У17 насны Азийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох 2 тамирчин 2,5 сая, Турк улсын Бурса хотод зохион байгуулагдсан насанд хүрэгчдийн гардан тулааны дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцсон 1 тамирчинд 1,0 Бүгд найрамдах Хятад улсын Тайвань хотод зохион байгуулагдах "Мастеруудын дэлхийн олимп"-д оролцох 1 тамирчинд 1,0 сая, Япон улсад зохион байгуулагдах Дичлгитын наадамд оролцох 2 тамирчинд 1,5 сая, Бахрейн улсад зохион байгуулагдах хүндийн өргөлтийн "Бахрейн-2025" тэмцээнд оролцох 1 тамирчинд 1,5 сая, Бүгд найрамдах Хятад ард улсын Далиан хотод зохион байгуулагдах Спорт өргөлтийн Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох 3 хүүхэд 1 багшид 2,0 сая Англи улсын Гибралтар хотод зохион байгуулагдах дартсын өсвөрийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчинд 1,0 сая төгрөгийн дэмжлэгийн тус тус үзүүлж олон улсын чанартай тэмцээн уралдаанд оролцох нийт 14 тамирчинд 14,5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Дээрх 14 тамирчнаас 3 тамирчин Тэргүүнд байранд шалгарч хос алтан медальтай олимпын аварга, 6 тамирчин гутгаар байранд шалгарч хүрэл медаль, 2 тамирчин шагналт 5 дугаар байранд шалгарсан амжилттай байна. 3 тамирчин тэмцээнд оролцохоор бэлтгэл хангаж байна.	
"Зорилт 3 "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, хүртээмжийг сайжруулах" зорилтын хүрээнд					

1	Арга хэмжээ 3.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан сургалт, арга хэмжээнд зорилтот бүлгийн иргэдийг хамруулж, хөгжих, оролцох боломжийг нэмэгдүүлнэ.	Сургалт арга хэмжээнд хамрагдсан иргэдийн хувиар.	45	45	Сургалт, хэлэлцүүлэг, нээлттэй хаалганы өдөрлөг болон урлаг, спортын тэмцээн уралдаан эрүүл мэндийн үзлэг оношилгоо эмчилгээнд 599 иргэн хамрагдсан нь нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэний 46,8 хувийг хамруулсан байна.	2025.01.02 2025.11.31	100
3	Арга хэмжээ 3.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах	Спорт, урлаг соёлын арга хэмжээ зохион байгуулсан тоогоор.	3	4	2025 оны 10 сарын байдлаар Энхийн чимэг эмийн сан, Бүтээгч гар, Амьдралын томилгоо зэрэг нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллага, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо, Монголын хараагүйчүүдийн холбооны Өвөрхангай салбар зөвлөлтэй хамтран сургалт, хэлэлцүүлэг, нээлттэй хаалганы өдөрлөг арга хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 254 иргэн, асран хамгаалагч 80 иргэн урлаг спортын тэмцээн уралдаанд 122 иргэн, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Өрхийн эрүүл мэндийн төвүүд, Элбэрэлт мед гэр бүлийн эмнэлэг, Ариунсанаа эмнэлгүүдтэй хамтран эрүүл мэндийн үйлчилгээнд 143 иргэн тус тус хамруулсан байна. Өссөн дүнгээр 1029 иргэнийг нийгмийн үйл ажиллагаанд оролцуулсан байна.	2025.01.02 2025.11.31	100
3	Арга хэмжээ 3.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй орчныг нэмэгдүүлнэ.	Хүртээмжтэй орчин бий болгосон байгууллага, аж ахуйн нэгжийн тоогоор	22	28	Арвайхээр сумын ерөнхий боловсролын 6 сургууль, 15 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байна.Ерөнхий боловсролын 6 сургууль, 1,3,9,12,13,15 дугаар цэцэрлэг нийт 13 байгууллагын гаднах налуу зам стандартын шаардлага хангасан байна.1,4,9,13,15 дугаар цэцэрлэгийн дотор орчин хөгжлийн бэрхшээлтэй хүний хүртээмжийг хангасан оо, барилгатай байна.Өрхийн эрүүл мэндийн төвүүд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүртээмжтэй орчин бүрдүүлсэн. 2024 онд хүртээмжийн үнэлгээ хийж заавар зөвлөмжийг 16 албан байгууллага, аж ахуй нэгжид хүргүүлснээр 2025 онд ажлын гүйцэтгэл үр дүнг шалгахад 6 байгууллага, аж ахуй нэгж гадна	2025.01.02 2025.11.31	100

				орчны хүртээмжээ нэмэгдүүлсэн байна. (Ачлал худалдааны төв, Ачтан-Ирээдүй эмнэлэг, Монгол агент дэлгүүр, Гэр бүл хүний хөгжлийн төв, 3,13 дугаар цэцэрлэг) 3,13 дугаар цэцэрлэг 1,5 сая төгрөгөөр гадна орчны хүртээмжийг нэмэгдүүлсэн.	
Зорилт 4. "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД					
Арга хэмжээ 4.1. ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх;	Тайлан мэдээний биелэлтийн хувь			Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг боловсруулан батлуулж хагас, бүтэн жилээр, сумын Сумын иргэдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлын тэмдэглэлээр өгсөн үүргийн биелэлт болон бусад хугацаатай тайлан мэдээг хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэн ажилласан.	2024.01.02 2024.12.01 100
1.		100	100		
Арга хэмжээ 4.2. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;	Ирсэн хариутай бичгийг хугацаанд нь шийдвэрлэсэн хувь	100	100	2025 оны жилийн эцсийн байдлаар захирамжийн төсөл 27, тушаалын төсөл 3 боловсруулан, 5 албан бичиг төлөвлөн, 27 албан бичиг ирснээс 5 хариутай албан бичгийг цаг хугацаанд нь хариуг албан тоотгоор болон цахимаар хүргүүлсэн. Мөн 18 өргөдлийг шийдвэрлүүлж ажилласан.	2025.01.02 2025.11.31 100
2.	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахих ажилласан эсэх	0	0	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чандлан сахих, төрийн албан хаагчийн хувьд хариуцсан ажилдаа хариуцлагатай хандаж, өөрөө өөрийгөө хөгжүүлэх, хувийн зохион байгуулалтаа сайжруулах талаар анхааран ажиллаж, байгууллагын дотоод журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж хэвшсэн.	2025.01.02 2025.11.31 100

3	Байгууллагаас байгуулсан нийтийг хамарсан арга хэмжээ, сургалт сурталчилгаанд хамрагдах.	Зохин байгуулсан арга хэмжээ, сургалтад хамрагдалтын хувиар.	100	100	Байгууллагаас зохион байгуулсан нийтийг хамарсан арга хэмжээ, сургалт сурталчилгаанд бүрэн хамрагдсан.		
---	--	--	-----	-----	--	--	--

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэ лтийн хувь
1	Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Бүсчилсэн хөгжил" хөдөлгөөний төвийн бүсийн "Спортын их наадам"-ын				Төвийн бүсийн спортын их наадмыг амжилттай зохион байгуулж зургаан сумын 600 гаруй тамирчид үндэсний бөх, үндэсний сур, шатайн харваа, шатар, 100 буудалт даам, волейбол, сагсан бөмбөг, ширээний теннисний төрлүүдээр өрсөлдөж бүсийн шилдгүүдээ шалгаруулсан.	2025.04.01 2024.04.15	100
2	Төндөрийн үнэлгээний хороонд ажиллах	Хууль журмын дагуу зохион байгуулах		100	3*3 сагсан бөмбөгийн талбай барих ажлын үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар ажиллаж төндөрийг хууль журмын дагуу зохион байгуулан ажиллаж байна.	2025.04.25 2025.12.31	100
3	Байгууллагын эцэг эхийн зөвлөлийн ажлын хэсэг	Зохин байгуулсан арга хэмжээ		100	Эцэг эхийн зөвлөлийн ажлын төлөвлөгөөг гаргаж хэрэгжилтийг ханган тайлан мэдээг гарган ажилласан.	2025.01.02 2025.11.31	100

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэ лтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 2.1. Хуульч сэтгэлгээний академийн "Хуульч шиг сэтгэж сурах нь" 22 хичээл бүхий цахим онлайн сургалтад хамрагдана.	Сертификат авсан байна.	1	1	1.Сургалтад сертификат авсан. 2.Монголын Улаан загалмайн нийгэмлэг, Бүгд найрамдах Хятад ард улсын Өвөр Монголын өөртөө засах орны Улаан загалмайн байгууллагаас зохион байгуулсан Анхны	2025.01.02 2025.11.31	100

					тусламжийн 40 цагийн сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан.		
2.	Арга хэмжээ 2.2. Монгол бичгийн унших, бичих ур чадвараа сайжруулж, албан бичгийг хос бичгээр бэлдэж боловсруулдаг болно.	Боловсруулсан төслийн хувиар	100	100	5 албан тоотыг хос бичгээр бэлдэж боловсруулсан байна.	2025.01.02 2025.11.31.	100

ТАЙЛАН ГАРГАХ АН:

НИЙГМИЙН БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН

М.ЭРДЭНЭЧИМЭГ

2025 оны 11 дүгээр сарын 28

**НИЙГМИЙН БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН М.ЭРДЭНЭЧИМЭГИЙН 2025 ОНЫ
ЖИЛИЙН АЖЛЫН, ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ
ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газар

Нэгжийн нэр: Нийгмийн бодлого

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1. “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх” зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1.	Арга хэмжээ 1.1.	60	10	70	70
2.	Арга хэмжээ 1.2.1	60	10	70	70
3.	Арга хэмжээ 1.2.2	60	10	70	70
4.	Арга хэмжээ 1.3.	60	10	70	70
5.	Арга хэмжээ 1.4.1	0	0	0	0
6.	Арга хэмжээ 1.4.2	60	10	70	70
7.	Арга хэмжээ 1.5.1	60	10	70	70
8.	Арга хэмжээ 1.5.2	60	10	70	70
9.	Арга хэмжээ 1.6.	60	10	70	70
10.	Арга хэмжээ 1.7.	60	10	70	70
11.	Арга хэмжээ 1.8.	60	10	70	70
Зорилт 2. “Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, иргэдийг эрүүл амьдралын хэв маягт төлөвшүүлэх” зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1.	Арга хэмжээ 2.1.	60	10	70	70
2.	Арга хэмжээ 2.2.	60	10	70	70
3.	Арга хэмжээ 2.3.	60	10	70	70
4.	Арга хэмжээ 2.4.	60	10	70	70
Зорилт 3. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, хүртээмжийг сайжруулах” зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1.	Арга хэмжээ 3.1.	54	10	64	64
2.	Арга хэмжээ 3.2.	60	10	70	70
3.	Арга хэмжээ 3.3	60	10	70	70
Зорилт 4. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах” зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1	Арга хэмжээ 4.1.	60	10	70	64
2	Арга хэмжээ 4.2.1	60	10	70	70
3	Арга хэмжээ 4.2.2	60	10	70	70
Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт					
1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1.	60	10	70	70
2.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2.	60	10	70	70
3.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3.	60	10	70	70
Дундаж оноо:				67,3	66,5

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	Арга хэмжээ 1.	100	15	15
2.	Арга хэмжээ 2.	100	15	2.5
Дундаж оноо			15	11.2

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй		7
2.	Дүн шинжилгээ хийх		7
3.	Асуудал шийдвэрлэх		7
4.	Хариуцлагатай байдал		7
5.	Ажлын цаг ашиглалт		7
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6.	Мэргэжлийн ур чадвар 1.		
7.	Мэргэжлийн ур чадвар 2.		
8.	Мэргэжлийн ур чадвар 3.		
Дундаж оноо			

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	7.91
2.	Багаар ажиллах	7.91
3.	Харилцаа	7.91
Дундаж оноо		7.91

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)	66.5
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	11.2
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	7
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	7.91
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		92.6

Үнэлгээ өгсөн:

Нэгжийн дарга

Төрийн жинхэнэ, адбан хаагч:

М.ЭРДЭНЭЧИМЭГ

2025 оны 11 дугаар сарын 11.

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

3207m gema

2025 оны дугаар сарын

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

2025 оны дүгээр сарын

Үнэлгээг баталгаажуулсан: Төсвийн шууд захирагч

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

С.ГАНЧИМЭГ

2025 оны дугаар сарын